

ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН АКАДЕМИЧ БАДАМЫН ЛХАМСҮРЭН¹

Д.Уламбаяр*

Билгийн улирлын тооллын XVI жаран 1927 оны улаагчин туулай жил эхэлж, 1986 оны улаан барс жил шувтарчээ. Монгол Улсын шинээр сэргэн мандсан түүх энэхүү хугацаанаас халин гарч аргын тооллын XX зууны туршид өрнөсөн билээ. Монголчууд бидний хувь заяанд дурдсан жаран онцгой ач холбогдол бүхий үйл явдлаар дүүрэн он жилүүд байв. Бадамын Лхамсүрэнгийн ухамсарт амьдрал, үйл ажиллагаа чухамхүү энэ жарантай орон зай, он цагийн хувьд үндсэндээ давхцжээ. Тиймээс ч тэрбээр өөрийгөө үе тэнгийнхнийхээ нэгэн адил XVI жарны үйл явдлын гэрч, ажиглагч төдий биш, гар бие оролцогч гэж үзэж байсан юм. Учир иймээс ч Б.Лхамсүрэн бээр өөрийн дурсамж номоо “Арван зургадугаар жаран мину” хэмээн нэрлэсэн учир энэ бөлгөө.

Дэлхийн II дайны дараа олон улсын харилцааны хүчний тэнцвэрт үндсэн өөрчлөлт гарч социалист систем бүрэлдэн тогтсон хийгээд Монгол Улсын тусгаар тогтнолыг өмнөд хөрш албан ёсоор *de jure* хүлээн зөвшөөрсөн, Монгол Улсын НҮБ-д гишүүнээр элсэх асуудал ноцтой тавигдаж эхэлсэнтэй уялдан дипломат албыг шинэчилж, өргөжүүлэн зохион байгуулах шаардлага

¹ Лхамсүрэн, Бадамын (1923-2016) Хэнтий аймгийн Цэнхэрмандал суманд төрсөн. 1942-1947 онд МУИС-ийг математикч-физикч мэргэжлээр дүүргэсэн. 1954-1958 онд Москвад ЗХУ-ын ГЯЯ-ны Дипломатын дээд сургуулийн (1974 оноос Дипломатын академи болон өөрчлөгдсөн) аспирантурт суралцаж, «Внешняя политика МНР и развитие её международных связей после второй мировой войны (1921-1957 гг.)» сэдвээр Монгол Улсын гадаад харилцааны түүхийн асуудлаар анх удаа түүхийн шинжлэх ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан. 1972-1975 онд ЗХУКН-ын ТХ-ны дэргэдэх Марксизм-Ленинизмын институтын докторантурт суралцаж «Воплощение в деятельности МНРП принципов интернационализма» сэдвээр түүхийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан. 1959 оны 3 дугаар сарын 13-нд дипломатын “Онц бөгөөд Бүрэн эрхт элчин” цол хүртсэн. 1961 онд Монгол Улсын ШУА-ийн сурвалжлагч гишүүн, 1990 онд ШУА-ийн жинхэнэ гишүүн, академич цол хүртжээ. 1947-1950 онд МАХН-ын ТХ-нд лектор, референт, 1950-1952 онд ГЯЯ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга, 1952-1954 онд Ерөнхий сайдын референт, 1958-1959 онд ГЯЯ-ны орлогч сайд, 1959-1961 онд СнЗ-ийн даргын соёлын асуудал эрхэлсэн орлогч дарга, 1961-1962 онд СнЗ-ийн орлогч дарга бөгөөд Дээд ба Тусгай мэргэжлийн дунд боловсролын Улсын Хорооны дарга, 1962-1972 онд МАХН-ын ТХ-ны Улс төрийн товчооны орлогч гишүүн, НТХ-ны Нарийн бичгийн дарга, АИХ-ын Тэргүүлэгчдийн Гадаад хэрэг эрхэлсэн комиссын дарга, Монгол-Зөвлөлтийн Найрамдлын Нийгэмлэгийн Төв Зөвлөлийн дарга, 1975-1981, 1984-1988 онд БНСЧСУ-ын нийслэл Прага хотноо олон улсын коммунист хөдөлгөөний «Энхтайван, социализмын асуудал» сэтгүүлийн Зөвлөлд суугаа МАХН-ын Төлөөлөгч, 1981-1982 онд МАХН-ын ТХ-ны Улс төрийн товчооны орлогч гишүүн, 1981-1984 онд МАХН-ын ТХ-ны дэргэдэх Нийгмийн ухааны институтын захирал, 1988-1990 онд МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Батмөнхийн зөвлөх, 1991-2003 онд ШУА-ын Олон улс судлалын хүрээлэнд зөвлөхөөр ажиллаж байв. “Алтан гадас”, “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Сүхбаатарын одонгоор 3 удаа шагнагджээ.

* ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн захирал

гарч иржээ.

Түүнчлэн Монгол Улс 1948 оны 10 дугаар сард БНАСАУ, 1949 оны 5 дугаар сард Албани, 1949 оны 10 дугаар сард БНХАУ, 1950 оны 4 дүгээр сард БНАГУ, Польш, Болгар, Чехословак, Унгар, Румынтай тус тус дипломат харилцаа тогтоосон байв.

Гадаад харилцаа өргөжин тэлж байгаатай холбогдуулан 1950 оны 4-6 дугаар сард МАХН-ын ТХ-ны УТТ-ны 29/52 дугаар тогтоол, БНМАУ-ын Ардын СнЗ-ын 38/67 дугаар тогтоолууд тус тус гарч, ГЯЯ-ны бүтэц, зохион байгуулалтыг өргөтгөж хоёр орлогч сайд, ерөнхий нарийн бичгийн даргын газар, консулын хэлтэс, нууцын тасгийг шинээр зохион байгуулж, ёслол, шинэ хүчний тасгийг хэлтэс болгосны дээр бүх хэлтэст орлогч эрхлэгч томилж, референтүүдийн тоог нэмсэн байна. ГЯЯ-ны сайдыг Ерөнхий сайд маршал Х.Чойбалсан хавсарч байсныг салгаж, ГЯЯ-ны сайдаар орлогч сайд Намтайширын Лхамсүрэнг, орлогч сайдад сайдын туслах Лхамнэрэнгийн Норовсамбуу, ГЯЯ-ны Дорнод хэлтсийн дарга Жамсрангийн Самбуу нарыг, Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгчээр МАХН-ын ТХ-ны суртал ухуулгын хэлтсийн гадаад бодлого, олон улсын харилцааны чиглэл хариуцсан референт Бадамын Лхамсүрэн нарыг тус тус томилжээ. Өмнө нь 1946-1950 онд ГЯЯ-ны Ерөнхий нарийн бичгийн даргаар Эрдэнэцогтын Намсрай ажиллаж байжээ. Тэрбээр мөн 1937-1946 онд ГЯЯ-ны орлогч сайдаар ажиллаж байв. Тухайн үед МАХН-ын ТХ-нд хоёр Лхамсүрэн ажиллаж байсны нэг нь дээр дурдсан Намтайширын Лхамсүрэн³ байсан юм. Тийнхүү Б.Лхамсүрэн 1950-1952 онд ГЯЯ-ны Ерөнхий нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэсэн бөгөөд 1951 оны 8 дугаар сард Москвад ЗХУ-ын ГЯЯ-ны ОУХДС-ийн анхны төгсөгчдийн нэг Т.Пүрэвжалыг МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөний 1951 оны 07 дугаар сарын

³ Лхамсүрэн, Намтайширын (1917-1992) 1917 онд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Галттай хэмээх газарт төрсөн. 1929-1934 онд Эрхүү хотын “Монгол курс”, 1931-1932 онд Эрхүү хотын хүн эмнэлэгийн техникум, 1939-1934 онд Эрхүү хотын эдийн засгийн Рабфак, 1934-1938 онд Эрхүү хотын ХАА-н институтийг агрономичийн мэргэжлээр, 1956-59 онд Москвад ЗХУКН-ын ТХ-ны дэргэдэх Нийгмийн ухааны академийн аспирантурт суралцаж, ХАА-н шинжлэх ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ. **1946-1951 онд ГЯЯ-ны орлогч сайд, 1951-1954 онд Ерөнхий сайдын орлогч бөгөөд ГЯЯ-ны сайд**, 1950 онд дипломатын Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд цол хүртсэн анхны дөрвөн дипломатчийн нэг. 1961-1963 онд ЗХУ-д суугаа ЭСЯ-нд II нарийн бичгийн даргаар ажиллаж байжээ. 1938-1942 онд МАА, тариалангийн яаманд орчуулагч, агрономич, ХАА-н техникумд багш, ХААЯ-нд хэлтсийн дарга, газрын орлогч дарга, дарга, дэд сайд, сайд, МАХН-ын ТХ-нд ХАА-н хэлтсийн эрхлэгч, 1941-1953 онд Намын шинэ хүчний дээд сургууль, МУИС-д багш, тэнхимийн эрхлэгч, 1942-1946 онд 1942-1946 онд “Намын амьдрал”, “Ухуулагч” сэтгүүлийн эрхлэгч, 1943-1945 онд МАХН-ын ТХ-нд лекторын товчооны дарга, Радио хорооны дарга, 1954-1956 онд МАХН-ын ТХ-ны Улс Төрийн товчооны орлогч гишүүн, Нарийн бичгийн дарга, 1959-1960 онд “Үнэн” сонины Москва дахь сурвалжлагч, 1960-1961 онд ХААДС-д эрдэм шинжилгээний ажилтан, 1964 онд «намын эсрэг бүлэг»-т оролцсон хэмээн шийтгэгдэж, Увс аймгийн Баруун турууны “Хар цагаан ус” гэдэг газар нутаг заагдаж, 1969-1974 онд баазын механикч, ногооны аж ахуйн тариалангийн бригадын дарга, 1974-1977 онд Баянхонгор аймагт эмийн ургамал тариалах агротехникч, Төвшрүүлэх, Амгалангийн САА-д ажиллаж байгаад тэтгэвэрт гарчээ. Н.Лхамсүрэнг 1990 онд цагаатгасан байна.

30-ны өдрийн 59/165 дугаар хурлын тогтоолыг үндэслэн Ерөнхий нарийн бичгийн даргын туслахаар томилж байжээ.⁴

1950 онд СнЗ-ийн 276 дугаар тогтоолоор Н.Лхамсүрэн сайдаар ахлуулсан ГЯЯ-ны коллегийг байгуулж, анхны гишүүдээр орлогч сайд Л.Норовсамбуу, Г.Пунцаг, Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Б.Лхамсүрэн, Ёслолын хэлтсийн дарга Б.Очирбат, Дорнод хэлтсийн эрхлэгч Д.Цэрэндорж нарыг томилжээ. Коллеги нь зөвлөх байгууллага бус, асуудал шийдвэрлэх, системийн хэмжээнд мөрдөх дүрэм, заавар батлах, шийдвэр гаргах зэрэг үйл ажиллагааг хамтын удирдлагын зарчмаар шийдвэрлэх эрхтэй байжээ. 1951 онд Коллегиор Консулын дүрэм, Консулын ажлын тайлан, мэдээ гаргах заавар, гадаад паспортын дүрэм, Консулын татваруудын заавар, дипломат шуудангийн заавар, тус улсад суугаа гадаадын элчин төлөөлөгч ба консулын дүрмээр ДТГ-ын үндсэн үйл ажиллагааны чиглэлийг зааж өгсөн байна.

Б.Лхамсүрэнг ГЯЯ-ны Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэж эхэлсэн үед 1950 оны 4 дүгээр сард Монгол Улсын ГЯЯ шинэ санал дэвшүүлж, түүнийг МАХН-ын ТХ-ны Улс Төрийн товчоо [УТТ] сайшааж, ЗХУ дэмжсэнээр Москва, Улаанбаатарт суугаа өөр өөрсдийн улсын Элчин яамны (Миссия) статусыг өргөжүүлэн Элчин Сайдын Яам (Посольство) болгосон байна. Үүнтэй холбогдуулан ЭСЯ-нд I, III нарийн бичгийн даргын орон тоог шинээр буй болгов. 1950 оны 4 дүгээр сарын 4-ний МАХН-ын ТХ-ны УТТ-ны 30 дугаар тогтоолоор 1946 оноос БНМАУ-аас ЗСБНХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин Н.Ядамжавыг Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар дэвшүүлэн томилж, мөнхүү дипломатын Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд цол олгож, ЭСЯ-нд зөвлөх Д.Адилбиш, худалдааны зөвлөх Ч.Авирмэд, I нарийн бичгийн дарга Ж.Банзар, Д.Цэрэндондов, II нарийн бичгийн дарга Д.Жадамбаа, III нарийн бичгийн дарга П.Шүхэр нар ажиллаж эхлэв. Шинээр томилогдсон элчин сайд Н.Ядамжав удалгүй ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга Николай М.Шверникт итгэмжлэх жуух бичгээ барьжээ.

1948 оноос БНМАУ-д суугаа ЗСБНХУ-ын Онц бөгөөд Бүрэн эрхт элчин Юрий К.Приходов 1950 оны 3 дугаар сарын 28-нд Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар дэвшин томилогдож, 4 дүгээр сарын 4-нд Улсын Бага Хурлын (УБХ) Тэргүүлэгчдийн дарга Г.Бумцэндэд ИЖБ-гээ шинээр дахин барив.

1950 оны 5 дугаар сарын 23-нд МАХН-ын ТХ-ны УТТ-ны 46 дугаар тогтоолоор Бээжинд ЭСЯ шинээр нээн Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Б.Жаргалсайханг томилж, мөнхүү дипломатын Онц бөгөөд Бүрэн

⁴ ГХТА. Тушаалын эмхтгэл.

эрхт элчин сайд цол олгож, I,II,III нарийн бичгийн даргаар Н.Далхжав, Д.Нямаа, Б.Готов нар томилогдж, мөн оны 7 дугаар сарын 3-нд элчин сайд Б.Жаргалсайхан БНХАУ-ын дарга Мао Цзедунд ИЖБ-гээ барьжээ.

БНХАУ-аас анх удаа БНМАУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Заят⁵ (Цзы Яа-тай) томилогдон ирж, 1950 оны 7 дугаар сарын 10-нд УБХ-ын Тэргүүлэгчдийн дарга Г.Бумцэндэд ИЖБ-гээ барив.

Мөн 1950 оны 6 дугаар сарын 8-нд БНАСАУ-ын Засгийн газар «...Ж.Самбууг томилж буй явдлыг... БНАСАУ-ын Засгийн газар...энэ 6 дугаар сарын 7-ны өдөр сэтгэл хангалуунаар зөвшөөрсөн болохыг...мэдэгдье» гэсэн байв. 1950 оны 6 дугаар сарын 14-нд УБХ-ын Тэргүүлэгчдийн 65 тоот зарлигаар Ж.Самбууг БНМАУ-аас БНАСАУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар тохоон томилж, мөнхүү дипломатын Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд цол олгосон байна. Улмаар 1950 оны зун Монгол Улсын ЭСЯ Пёнъян хотноо байгуулагдан үйл ажиллагаа эхэлж, элчин сайд Ж. Самбуу 1950 оны 8 дугаар сарын 11-нд БНАСАУ-ын Ардын Дээд Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ким Ду-бонд ИЖБ-гээ барьжээ. Өөрөөр хэлбэл Солонгосын дайн эхэлсэн тэр зун байв. ЭСЯ-нд зөвлөх бөгөөд I нарийн бичгийн дарга Х.Санжмятав, II нарийн бичгийн дарга Л. Пүрэв нар ГЯЯ-наас томилогджээ.

БНАСАУ-ын анхны Элчин сайд Ким Ёнг-жин⁶ болон ЭСЯ-ны бүрэлдэхүүн III Нарийн бичгийн дарга Сон Юү-гюн, атташе Ий Зя-хон, атташегийн гэргий Ким Ген-сун, атташе Юү Сен-дин нарыг⁷ хойд хил Сүхбаатарт угтаж авахаар ГЯЯ-ны Ёслолын хэлтсийн эрхлэгч Б.Очирбат, Дорнод хэлтсийн орлогч эрхлэгч Б.Дөрвөлжин, Европын хэлтсийн ажилтан Ц.Чимид, Төв рестораны тогооч эмэгтэй Сиймаа, байлдагч Лувсандорж, бие хамгаалагч ахмад Азар нар томилогдож, төлөөлөгчид 1951 оны 4 дүгээр сарын 13-нд Улаанбаатараас гарч 14-нд Сүхбаатар хотноо хүрэлцэн очжээ. Дөрвөн хоног хүлээсний эцэст 1951 оны 4 дүгээр сарын 18-ны өглөөний 4 цаг 40 минутад БНАСАУ-ын элчин сайд, бусад дипломат ажилтнуудын хамт хүрэлцэн ирэхэд Ёслолын хэлтсийн эрхлэгч Б.Очирбат нар угтан авч, Сүхбаатар хот дахь зөвлөлтийн цэргийн ангийн зочид буудалд амраагаад өдрийн 14 цаг 30 минутад галт тэргэнд сууж Улаанбаатар хотыг зорьж байжээ.

Улмаар 4 дүгээр сарын 19-нд Улаанбаатарт төлөөлөгчдийг ГЯЯ-ны

⁵ **Ji Yatai** (吉雅泰1901-68) was a Chinese diplomat. He was the First Ambassador of the People's Republic of China to the MPR (July 1950-July 53). Educated in KUTV, Moscow, USSR.

⁶ **Kim Yeong-jin**. СХН-ын ТХ-ны гишүүн, КУТВ-т суралцсан, Москвад БНАСАУ-ын ЭСЯ-нд түр ажилласан.

⁷ ГХТА. Ф.3, ХН 20 архивт дипломат төлөөлөгчдийн нэрс зөвхөн монгол галигаар бичигдсэн байна.

сайд Н.Лхамсүрэн, орлогч сайд Г.Пунцаг, Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Лхамсүрэн, Улаанбаатар хотын Захиргааны дарга Г.Багаа, хотын комендант дэд хурандаа Зандраа, Дорнод хэлтсийн эрхлэгч Д. Цэрэндорж, Ёслолын хэлтсийн орлогч Г.Минжүүр нар болон Зөвлөлт, Хятадаас тус улсад суугаа элчин сайд нар угтаж авсан байна. 1951 оны 4 дүгээр сарын 24-нд элчин сайд Ким Ёнг-жин УБХ-ын Тэргүүлэгчдийн дарга Г.Бумцэндэд ИЖБ-гээ өргөн барьжээ. Эдгээр бүх үйл явц Солонгосын дайны эхний хамгийн хүнд өдрүүдэд болж өнгөрчээ.

1950-1953 оны Солонгосын дайны жилүүдэд Ерөнхий сайдын орлогч Б.Ламжаваар удирдуулсан «Солонгосын ард түмэнд туслах хөдөлгөөнийг зохион байгуулах тусгай комисс»-ыг байгуулахад ГЯЯ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга А.Б.Лхамсүрэнг комиссын нарийн бичгийн даргаар томилжээ. 1951 оны намар МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Ч.Сүрэнжав, Б.Лхамсүрэн, сүүлд дэслэгч генерал, хөдөлмөрийн баатар болсон Ж.Жамъян тэргүүтэй төлөөлөгчид БНАСАУ-д айлчлан хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 3 жилийн ойн арга хэмжээнд оролцон 3 дахь удаагийн бэлгийн цувааг гардуулан өгчээ. 1952 онд Б.Лхамсүрэн тусламжийн бэлгийн цувааг хүргэх төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж хоёрдахь удаагаа БНАСАУ-д очиж байв. СХН-ын ТХ, Засгийн газар, Монголын төлөөлөгчдийг халуун дотно хүлээн авч, Монголын ард түмний тусламжийг өндөр үнэлж фронтын шугам дээр байлдаж байсан цэргийн анги нэгтгэлүүдээр явж, Монголын төлөөлөгчдийг танилцуулж байв. Тэнд «БНМАУ-аас үзүүлсэн дэмжлэг, тусламж» гэсэн нэртэй олон самбаруудтай булан гаргаж байжээ. Монгол агт, морьдыг «Монголын сайн дурынхан» гэж нэрлэж байснаас гадна фронтын зурвас нутгуудын зам муутай, шавар намаг ихтэй нуга, хөндий, гол горхи, уул даваануудад их буу, миномёт, байлдааны бусад техник хэрэгслэлийг тээвэрлэхэд чухал хувь нэмэр оруулсан монгол морьдод хувийн нэр өгч, зургийг нь самбар дээр тавьж, «баатар морь» гэж цол өгч байжээ.

Тухайн үед ГЯЯ Монгол Улсын гадаад харилцааг хөгжүүлэхийн тулд улс орнуудын талаар судалгаа, лавлах, танилцуулга бэлтгэх, гадаад орны радио нэвтрүүлгээс мэдээлэл олж авах, гадаадад суралцах оюутны асуудлыг эрхлэх, бүх төрлийн виз, паспорт олгох асуудлыг эрхлэн явуулах болов. 1951 оноос эхлэн яамны ажилтнууд өөрсдийн хариуцсан чиглэлээр тухайн онд олон улсын харилцаанд болсон томоохон үйл явдлын мэдээ хөтөлж гаргадаг болсон байна.

1951 онд БНМАУ-ын гадаад паспортыг шинэ крилл үсгээр хэвлүүлж, паспорт, визийн бүртгэл, анкетыг шинэчлэн мөрдүүлжээ. Сайд нарын

Зөвлөлийн 204 дүгээр тогтоолоор гадаад улстай байгуулсан бүх гэрээ, хэлэлцээрийн эх хувийг ГЯЯ-нд төвлөрүүлэн хадгалж байхаар шийдвэрлэсэн нь эдүгээ Монгол Улсын гадаад улс орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн төрөлжсөн баримтын сан хөмрөг болон хадгалагдаж байгаа юм.

Үнэхээр Б.Лхамсүрэнгийн анхлан ГЯЯ-нд ажилласан жилүүдэд Монгол Улсын гадаад харилцааны цар хүрээ өргөжин бэхжиж эхэлсэн үе байв.

Монгол Улсын Засгийн газар гадаад харилцаагаа эрхлэн явуулахад мэргэжлийн дипломат боловсон хүчин дутагдаж байсныг харгалзан 1946 оноос эхлэн үндэсний дипломат ажилтан бэлдэхэд тусгайлан анхаарч Москвад ЗХУ-ын ГЯЯ-ны Олон улсын харилцааны дээд сургуульд С.Аварзэд, Ш.Бира, М.Дүгэрсүрэн, Б.Лочин, Т.Пүрэвжал, О.Хосбаяр зэрэг оюутнуудыг анх илгээж, Б.Лхамсүрэнг ГЯЯ-ны удирдлагад ажиллаж байх цаг дор тэд 1951 онд сургуулиа амжилттай төгсч иржээ. 1950-иад оноос Монгол Улсын гадаад харилцааны түүхийн асуудлыг ч судлахад тухайлан анхаарч Б.Лхамсүрэн Москвад ЗХУ-ын ГЯЯ-ны Дипломатын дээд сургуулийн аспирантурт «Внешняя политика МНР и развитие её международных связей после второй мировой войны (1921-1957 гг.)» сэдвээр суралцаж 1958 онд, Ш.Сандаг⁸ «Образование Монгольского феодально-теократического государства и его внешняя политика (1911-1919 гг.)»⁹ сэдвээр Москвад ЗХУ-ын ГЯЯ-ны ОУХДС-ийн аспирантурт суралцаж 1958 онд анх удаа дурдсан чиглэлээр түүхийн шинжлэх ухааны дэд эрдэмтний зэргийг тус тус амжилттай хамгаалсан юм.

Б.Лхамсүрэн бээр дурсамждаа өгүүлэхдээ: «ГЯЯ-нд ажилласан жилүүд бол миний хувьд олон улсын харилцааг судлах, дипломат баримт бичиг боловсруулах, дипломат албанд суралцах он жилүүд байв...Марксизм-ленинизмийн оройн их сургуульд олон улсын харилцааны түүхийн хичээлийг зааж, энэ зорилгоор өөрийгөө бэлтгэх ажил надад их тустай байсан юм. Энэ үед л дурдсан чиглэлээр судалгааны ажил хийх санаа анх

⁸ **Сандаг, Шагдарын** (1928-2007) Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд төрсөн Оросын буриад. 1945-1949 онд МУИС-ийн түүхийн салбарыг дүүргэсэн. 1949-1954 онд МАХН-ын ТХ-ны Худалдаа-үйлдвэрийн хэлтэст референт, НТХ-ны дэргэдэх Намын дээд сургуулийн Орос хэлний тэнхимийн эрхлэгч, түүхийн багш, 1954-1958 онд Москвад ЗХУ-ын ГЯЯ-ны ОУХДС-ийн аспирантур, 1958-1959 онд ГХЯ-ны Хэвлэл мэдээллийн хэлтсийн дарга, 1959 оноос ШУА-ийн түүхийн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, 1974-1976 онд ШУА-ийн Дорно дахин судлалын хүрээлэнд секторын эрхлэгч, 1976-1986 онд Дорно дахины судлалын хүрээлэнд эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, 1978 онд ЗХУ-ын ШУА-ийн Дорно дахин судлалын хүрээлэнд “Внешняя политика МНР: 1921-1976 гг.” сэдвээр түүхийн шинэлэх ухааны докторын зэрэг хамгаалсан. 1986-1991 онд Дорно дахин судлалын хүрээлэнгийн захирал, 1991-1996 онд Беркели дэх Калифорнийн их сургуульд зочин профессор, Тайваньд судлаачаар ажиллаж байжээ.

⁹ Сандаг Ш. “Образование Монгольского феодально-теократического государства и его внешняя политика (1911-1919 гг.)” Автореф. канд. дисс., М.: 1958

төрж, ийм ажлын аргагүйн үндсийг эзэмшихийг чармайж байв. 1951 онд өөртөө мөрдлөг болгохоор бэлтгэсэн нэг материалд “бусдын санаа, хуучин баримтлалд шүүмжлэлтэй хандаж, аливааг өөрийн санаа бодлын үүднээс авч үзэх хэрэгтэй” гэж онцлон тэмдэглэж билээ» гэж бичсэн юм. Хожим тэрбээр өгүүлэхдээ «физик-математикийн ангийг улаан дипломтой төгссөн минь аливаа юмс үзэгдлийн мөн чанарыг товч, тодорхой илэрхийлэн гаргах, логик сэтгэлгээгээр хандах боломж олгосон» гэжээ.

1952 онд маршал Х.Чойбалсан нас барж, 5 дугаар сард Ерөнхий сайдаар Ю.Цэдэнбал томилогдсоны дараа ГЯЯ-ны сайд Н.Лхамсүрэнгийн санал болгосноор Б.Лхамсүрэн СнЗ-ийн ажлын албанд шилжиж, Ерөнхий сайдын референт болжээ. Шинэ албанд томилогдоод Ерөнхий сайдын гадаад харилцааны бичиг баримтыг төлөвлөн боловсруулах, бусад олон чухал үүрэг даалгаварыг гүйцэтгэх болсон байна. Энэ үед Европ-Азийн социалист орнуудын харилцаа болон тэдгээртэй БНМАУ-ын тогтоосон харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн төлөвийг нээсэн чухал үйл явдлын нэг нь ЗХУ, БНХАУ-ыг Монголын нутгаар холбосон төмөр зам тавьж, ашиглалтад оруулсан явдал байв. Төмөр зам тавих асуудлаар хэлэлцээр байгуулахаар гурван улсын удирдагчид 1952 оны 9 дүгээр сарын 15-нд Москвад уулзах үед Б.Лхамсүрэн Ерөнхий сайд Ю.Цэдэнбалыг дагалдан төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж явах завшаан тохиожээ. Энэхүү хэлэлцээрт БНМАУ-ын Ерөнхий сайд Ю.Цэдэнбал, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жоу Энълай, ЗСБНХУ-ын СнЗ-ийн Нэгдүгээр орлогч дарга бөгөөд ГЯЯ-ны сайд А.Я.Вышинский нар гарын үсэг зурж, И.В.Сталин тэргүүтэй Зөвлөлтийн удирдагчид байлцжээ. Москвагийн энэхүү уулзалт гурван хөршийн удирдагчдын хамгийн анхны дээд түвшний уулзалт байв. Дурдсан үйл явдал түүний олон улсын өндөр дээд түвшний арга хэмжээнд оролцсон анхны тохиолдол байсан бөгөөд тиймээс ч томоохон туршлага болсон нь мэдээж.

Уг хэлэлцээрийн үр дүнд Улаанбаатар-Замын-Үүд-Жинчиний хооронд төмөр зам барихаар тохиролцож, бүтээн байгуулалтын ажил амжилттай өрнөж эхэлжээ. 1955 оны 12 дугаар сарын 31-нд Улаанбаатар-Замын-Үүдийн төмөр замыг нээх ёслолын үйл ажиллагаа Улаанбаатарт болж, 1956 оны 1 дүгээр сарын 1-нээс ЗСБНХУ, БНМАУ, БНХАУ-ын хооронд төмөр замын шууд харилцаа нээсэн тухай дэлхийн улс орнуудад зарлан тунхагласан байна. 1956 оны 1 дүгээр сарын 3-нд Монгол, Хятадын хил дээр төмөр замыг холбосон мөнгөн хадаасыг хадах ёслолын ажиллагаа болж, БНМАУ-ын Ерөнхий сайд Ю.Цэдэнбал, ЗСБНХУ-ын Зам харилцааны сайд Б.П.Бещев, БНХАУ-ын Зам харилцааны сайд Тэнь Дэюан нар оролцсон байна.

1950-иад оны эхнээс МАХН-ын ТХ, Засгийн газар Монгол Улсын гадаад бодлого, олон улсын харилцааны түүхийн асуудлыг ч судлах тухайд чухалчлан анхаарч байсан тухай дээр тэмдэглэсэн билээ. Б.Лхамсүрэн ГЯЯ-нд ажиллах үеэсээ судалгааны материал цуглуулж байсныгаа НТХ-ны архив, Засгийн газрын архивт үргэлжлүүлж, Монгол Улсын гадаад бодлого, олон улсын харилцааны сэдвээр эрдэм шинжилгээний ажил хийхээр ЗХУ-д явж суралцахыг эрмэлзэж байв. Улмаар Ерөнхий сайд Ю.Цэдэнбал Б.Лхамсүрэнг ЗХУ-д гадаад харилцааны чиглэлээр аспирантурт суралцах асуудлыг хэлэлцэхэд бүрэн дэмжиж, тийнхүү тэрбээр Москвад ЗХУ-ын ГЯЯ-ны Дипломатын дээд сургуулийн (1974 оноос Дипломатын академи болон өөрчлөгдсөн Д.У) аспирантурт суралцах болжээ. Академид суралцах үедээ Ази, Европ, Америкийн орнуудын шинэ, нэн шинэ үеийн түүх, олон улсын эрхзүй, олон улсын харилцаа, дипломат, консулын алба, дипломат ёслолын тухай лекц сонсож, англи хэл гүнзгийрүүлэн судлах боломж олгосны ачаар О.Латтимор, Ж.Фритерс зэрэг өрнөдийн эрдэмтдийн бүтээлийг уншиж ашиглах болсон байна. ЗХУ-ын ГЯЯ-ны архивын материалуудтай бололцооны хэрээр танилцахын зэрэгцээ ЗХУКН-ын ТХ-ны дэргэдэх Нийгмийн ухааны академийн мэргэжлийн хичээлийн лекцэнд ч суух болж, мэдлэгээ гүнзгийрүүлж байсан ажээ.

Б.Лхамсүрэнгийн эрдэм шинжилгээний ажлын удирдагчаар олон улсын харилцаа, Алс Дорнодын орнууд, түүний дотор японы түүхийн нэрт эрдэмтэн, ЗХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн, түүхийн шинжлэх ухааны доктор, дипломатч Е.М.Жуков ажиллажээ. Тэрбээр «Всемирной истории» 10 боть бүтээлийн зохиогчдын нэг билээ. Москвад 4 жил суралцаж, 1958 онд «Внешняя политика МНР и развитие её международных связей после второй мировой войны (1921-1957 гг.)» сэдвээр анх удаа түүхийн шинжлэх ухааны дэд эрдэмтний зэргийг амжилттай хамгаалав. Диссертаци зохиол нь үндсэн гурван бүлэгтэй байсан агаад нэгдүгээр бүлэгт: 1921-1945 оны Монголын гадаад бодлогын үндсэн асуудал, тойм, хоёрдугаар бүлэгт: Дэлхийн II дайн дууссаны дараах үеийн Монгол Улсын гадаад харилцааны хөгжилт, гуравдугаар бүлэгт: Социалист систем бүрэлдсэн үеийн БНМАУ-ын гадаад бодлогын асуудлыг тодорхойлжээ. Гадаад Монголын *status quo*-г холбоотон гурван гүрний удирдагчид Ялтын бага хурлаар хэлэлцэж, хүлээн зөвшөөрсөн тухай асуудал диссертаци зохиолд анх удаа хөндөгдсөн юм.

Тэрбээр Москвад аспирантурт суралцаж байх ахуй дор тухайн үеийн онол-улс төрийн томоохон тогтмол хэвлэл болох “Современная Монголия” сэтгүүлийн 1957 оны №5-6, 1958 оны №1, №5-6-д диссертаци, эрдэм шинжилгээнийхээ ажилд тулгуурласан «Из истории внешних сношении

Монгольской Народной Республики (1921-1945 гг.)», «Из истории внешних сношении Монгольской Народной Республики (1945-1957 гг.)» «МНР в борьбе за мирное сосуществование» цуврал томоохон өгүүллүүдээ дараалуулан нийтлүүлсэн юм. Энэ нь БНМАУ-ын гадаад харилцааны түүхийн талаар хэвлэгдсэн анхны томоохон цуврал өгүүлэл байв. Б.Лхамсүрэн дурсамждаа өгүүлэхдээ: «Энэ диссертаци тэр үед Монгол Улсын гадаад харилцааг тусгайлан авч үзсэн анхны судалгаа байсан бөгөөд түүнд Монгол, Зөвлөлтийн хаалттай байсан архивуудаас бололцоотой материалуудыг ашиглаж, дотоод, гадаадын ном, хэвлэл, нийтлэлийн дүгнэлтүүдэд өөрийн бодол санааны үүднээс шүүмжилтэй хандаж, Монголын гадаад бодлогын бие даасан байдал, идэвхтэй үйл ажиллагааг нотлон харуулахыг эрмэлзсэн. Гэхдээ тухайн үеийн үзэл суртал, улс төрийн баримтлалын хүрээнд баригдаж гадаад харилцааны талаарх бодит үнэнийг бүрэн тусгаж чадаагүй нь мэдээж. Тийм дутагдлыг хожмын судалгаандаа засахыг оролдсоныг цухас дурдъя» гэсэн байдаг. Хожим академич Б.Лхамсүрэн ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс эрхлэн “XX зууны Монгол” төслийн хүрээнд «Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол» зохиолоо бичиж 1995 онд хэвлүүлсэн юм. Тэрбээр олон жилийн судалгааны үр дүнгээ нэгтгэж, Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнолын түүхэн асуудлыг шинэ сэтгэлгээний үүднээс хөндөж судлах эхлэлийг тавьсан билээ.

Б.Лхамсүрэн Москвад аспирантурт суралцаж байсан тухайгаа өгүүлэхдээ: БНМАУ социалист системийн бүрэлдэхүүн хэсэг болон төлөвшиж байсан нөхцөлд тэр үеийн нам, засгийн удирдагчид гадаадад айлчлахдаа ЗХУ-д сурч байсан аспирант оюутнуудыг гадаад арга хэмээнд татан оролцуулах явдал нэг биш удаа гарч байсныг дурдаад, тийм боломж өөрт нь хоёр ч удаа тохиосныг тэмдэглэсэн байна. 1957 оны 3 дугаар сард Москвад хоёр улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол Улсын социалист байгуулалтад тусламж үзүүлэх асуудлаар тохиролцож Монгол-Зөвлөлтийн дээд түвшний хэлэлцээ хийх үед Б.Лхамсүрэнг ажлын хэсэгт оролцуулж байсан явдал болно. Дараах нь 1957 оны 8-9 дүгээр сард Монголын Засгийн газрын төлөөлөгчид Дорнод Европын социалист найман оронд (БНАГУ, БНБАУ, БНУАУ, БНСЧСУ, БНСРУ, БНПАУ, ХБНСЮУ, БНААлбаниАУ) албан ёсны айлчлал хийх үед Москвад ОУХДС-д сурч байсан Д.Чимиддоржтай хамт төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж, улс орон бүрт хэлэх үг, албан мэдэгдэл зэрэг 4-6 баримт бичгийн төслийг зөвлөх Б.Жаргалсайхантай хамт шөнөжин сууж, өглөөний 4-5 цагт бэлэн болгодог, тэдгээрийг Ю.Цэдэнбал дарга үзэж засдаг байсныг тэмдэглэсэн байдаг.

Б.Лхамсүрэнг Москвад эрдмийн зэрэг амжилттай хамгаалж ирсэн

даруйд Засгийн газрын шийдвэр гарч, 1958 оны 8 дугаар сард ГЯЯ-ны орлогч сайдаар томилсон байна. Тийнхүү ГЯЯ-ны сайдаар томилогдоод удаагүй байсан П.Шагдарсүрэнгийн удирдлага дор идэвх санаачлагатай ажиллаж эхэлжээ. Удалгүй 1959 оны 3 дугаар сарын 13-нд Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн [1960 оноос АИХ-ын Тэргүүлэгчид гэж нэрлэх болжээ Д.У] дарга Ж.Самбуугийн зарлиг гарч, Монгол Улсын дипломат албанд идэвх зүтгэлтэй ажилласныг нь үнэлэн Б.Лхамсүрэнд дипломатын Онц бөгөөд Бүрэн эрхт элчин цол хүртээжээ.

Б.Лхамсүрэнг ГЯЯ-ны орлогч сайдаар томилогдох үед ГЯЯ-ны үйл ажиллагааны цар хүрээ үлэмж өргөжиж, БНМАУ 1954 оны 11 дүгээр сард Ардчилсан Вьетнам улстай, 1955 оны 12 дугаар сард шинээр тусгаар тогтнолоо олсон капиталист Энэтхэг улстай, 1956 оны 9 дүгээр сард Бирмтэй, 11 дүгээр сард ХБНСЮУ, 12 дугаар сард Индонезтай, 1956 онд Прага, Дели, 1957 онд Будапешт, 1958 онд Берлин, 1959 онд Варшавт ЭСЯ, Ардчилсан Вьетнамд Байнгын Түр хамаарагчийн газар, 1957 онд Хөх хотод Ерөнхий консулын газрыг тус тус нээн ажиллуулж эхэлсэн байв. 1957 онд Гана, Тунис, Судан, Малайз, 1958 онд Гвиней, Алжир зэрэг улсууд тусгаар тогтнолоо зарласныг хүлээн зөвшөөрч байгаагаа мэдэгдэхийн хамт дипломат харилцаа тогтооход бэлэн гэдгээ илэрхийлсэн байна. Мөн ГЯЯ зөвхөн улс төрийн харилцаа эрхэлж, соёлын харилцааг төрийн бусад байгууллагууд эрхэлж байв. Гадаад харилцаа салбараар тарж байрласныг арилгах, гадаад бодлогын нэгдмэл, залгамж шинж чанарыг хангахыг чухалчилж, холбогдох санал дүгнэлтийг НТХ, Засгийн газарт оруулаад байв.

Гэвч Б.Лхамсүрэнг 1959 оны МАХН-ын ТХ-ны III Бүгд хурлын дараа НТХ-ны УТТ-ны хуралдаанаар ГЯЯ-ны орлогч сайдын албан тушаалаас чөлөөлж, СнЗ-ийн даргын соёл, боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн орлогч даргаар дэвшүүлэн томилжээ. Тэрбээр гадаад харилцааны чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалж ирээд ГЯЯ-нд орлогч сайдаар удаагүй, нэгэнт томилогдсон ажил дээрээ үр дүн гаргамаар байгаагаа учирласан боловч тусыг эс олсон ажгуу.

Б.Лхамсүрэн 1962-1972 онд МАХН-ын ТХ-ны УТТ-ны орлогч гишүүн, НТХ-ны үзэл суртал эрхэлсэн Нарийн бичгийн даргаар ажилласан билээ. Дурдсан хугацаанд тэрбээр АИХ-ын Тэргүүлэгчдийн газрын Гадаад хэрэг эрхлэсэн комиссын дарга, Монгол-Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэгийн Төв Зөвлөлийн даргын албыг 10 жил хавсран ажиллаж, тус улсын гадаад харилцаа, юуны өмнө Монгол-Зөвлөлтийн найрамдалт харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх үйлст идэвхтэй ажиллажээ.

МАХН-ын ТХ-ны үзэл суртал эрхэлсэн нарийн бичгийн даргын эрхлэх ажлын чиг үүрэгт МАХН-ын ТХ-ны дэргэдэх Намын түүхийн институт орж байжээ. Тус институт 1955 оны 12-р сарын 19-нд МАХН-ын ТХ-ны дэргэд анх зохион байгуулагджээ. Намын түүхийн институт нь МАХН-ын товч түүх¹⁰, МАХН-ын IV Программыг¹¹ боловсруулж гаргах, К.Маркс, Ф.Энгельс, В.И.Ленинийн сонгодог бүтээлүүдийг¹² эх хэлнээ орчуулах, БНМАУ-ын капиталист биш хөгжлийн түүхэн туршлагыг нэгтгэн дүгнэх, БНМАУ-д социализмын материал-техникийн баазыг байгуулах, социалист нийгмийн харилцааг боловсронгуй болгох, социалист бие хүнийг төлөвшүүлэх, социалист эдийн засгийн интеграцийг хөгжүүлэх Цогцолбор Программ¹³, БНМАУ-ыг ЗСБНХУ, ах дүү социалист бусад орнуудтай бүх талаар ойртон нягтруулах үйл явц¹⁴, гадаад харилцааг хөгжүүлэх талаар МАХН-аас явуулж буй интернационалч үйл ажиллагаа, олон улсын коммунист, ажилчны хөдөлгөөн, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн зэрэг социализмын онол-практикийн асуудлыг боловсруулан гаргаж байжээ.

Академич Б.Лхамсүрэнгийн гадаад харилцааны салбарт ажиллаж байсан өөр нэг чухал чиглэл нь МАХН-ын гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагаанд биечлэн оролцож байсан явдал болно. Тухайн үед МАХН БНМАУ-ын Үндсэн хуулийн заалтын дагуу улс орныг удирдан чиглүүлэгч манлай хүчин мөн байсны хувьд түүний гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагаа нэн чухал байсан нь ойлгомжтой. Тэрбээр 1972-1975 онд Москвад ЗХУКН-ын Төв Хорооны дэргэдэх Марксизм-Ленинизмийн институтийн докторантурт бүрэн хөтөлбөрөөр суралцаж, «Воплощение в деятельности МНРП принципов интернационализма» сэдвээр 1975 онд түүхийн шинжлэх ухааны докторын зэргийг амжилттай хамгаалсан юм. Б.Лхамсүрэн эх орондоо эрдэм шинжилгээний ажлаа үргэлжлүүлэх сонирхолтой байсан боловч түүнийг өөр ажилд томилох асуудал МАХН-ын

¹⁰ МАХН-ын товч түүхийн анхны хэвлэл 1967 онд хэвлэгдэн гарч ШУА-ийн сурвалжлагч гишүүн Б.Лхамсүрэн Редакцийн комиссын даргаар ажиллажээ.

¹¹ МАХН-ын IV Программыг 1966 онд хуралдсан МАХН-ын XV Их хурлаас батлан гаргасан юм.

¹² К.Маркс, Ф.Энгельсийн 3 боть түүвэр зохиол, В.И.Ленинийн 35 боть зохиолыг монгол хэлнээ орчуулан гаргасан.

¹³ 1969 оны 4 дүгээр сард Москва хотноо хуралдсан ЭЗХТЗ-ийн XXIII тусгай Чуулганаар ах дүү социалист орнуудын бүх талын хамтын ажиллагааг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэх Үндсэн чиглэлийг тодорхойлсны дагуу “Социалист эдийн засгийн интеграцийг хөгжүүлэх Цогцолбор Программ”-ыг Зөвлөлийн гишүүн орннуд хамтран боловсруулж, 1971 онд хуралдсан ЭЗХТЗ-ийн XXV Чуулганаар санал нэгтэй баталж байжээ.

¹⁴ 1976 онд хуралдсан МАХН-ын XVII Их хурлаас БНМАУ-ыг ЗСБНХУ, ах дүү социалист бусад оронтой бүх талаар ойртон нягтруулах улс төрийн чиг шугамыг тодорхойлон заажээ. Ю.Цэдэнбал XVII Их хурлын тайлан илтгэлд тэмдэглэхдээ: «Ах социалист орнуудыг бүх талаар ойртон нягтруулж, тэдгээрийн интеграцийг хөгжүүлэх явдал бол дэлхийн социалист системийн хөгжлийн бодит зүй тогтол мөн» гэжээ. Ийнхүү ах дүү коммунист, ажилчны намууд бодит социализмын онол-практикийн түүхэн туршлагыг нэгтгэн дүгнэж, социалист интернационализмыг бүтээлчээр баяжуулан хөгжүүлж байна гэж үзэж байжээ.

ТХ-ны УТТ-н дээр нэгэнт шийдэгдсэн бөгөөд, тэгээд ч мэргэжлийн дагуу хэмээн үзэж шинэ ажилд томилогдоход татгалзаагүй юм.

Тэгээд удалгүй Прагад байрлах олон улсын коммунист, ажилчны хөдөлгөөны онол-улс төрийн сар тутмын «Энхтайван, социализмын асуудал» [ЭТСА] сэтгүүлийн Зөвлөлд суугаа МАХН-ын Төлөөлөгчөөр 1975-1981, 1984-1988 онд хоёр удаа томилогдон ажиллажээ. Дурдсан албан тушаал нь Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын зэрэглэлээс дээгүүрт тооцогдож байжээ.

1957 оны коммунист, ажилчны намуудын Москвагийн Зөвлөлгөөнөөр олон улсын нэр хүндтэй «Энхтайван, социализмын асуудал» сэтгүүлийн Хэрэг эрхлэх газрыг Прага хотноо байгуулах шийдвэр гарч анхны дугаар нь 1958 оны 9 дүгээр сард хэвлэгдэн нийтийн хүртээл болжээ. ЭТСА сэтгүүл хөгжлийнхөө оргил үедээ 1975 оны байдлаар дэлхийн 145 оронд 32 хэлээр 500 мянган хувиар хэвлэгдэн гарч, Прага дахь сэтгүүлийн Зөвлөлд 30 гаруй орны улс төрийн намууд Байнгын төлөөлөгчдөө томилон суулгаж байсан ажээ. Сэтгүүлд социалист байгуулалтын онолын асуудал, дэлхийн коммунист хөдөлгөөны стратеги, тактик, шинэ колончлол, Ази, Африк, Латин Америкийн орнуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, хөгжлийн социалист чиг баримтлал, нийгмийн янз бүрийн байгуулалтай улс орнууд энхтайвнаар зэрэгцэн орших асуудал, хөгжингүй капиталист орнууд дахь ажилчин ангийн байдал, Ойрхи дорнодын хямрал, арабын орнуудын тулгамдсан асуудал, олон улсын ажилчны хөдөлгөөн, «гуравдахь ертөнц»-ийн орнууд дахь үндэстэн дамнасан корпорациудын үйл ажиллагаа, олон улсын харилцааны зангилаа асуудал, дайн, энхийн асуудал, зэвсэг хураах, зэвсэглэлд хяналт тавих, дэлхийн глобал асуудлын талаар нэр хүндтэй зохиогчдын улс төр-онолын өгүүллүүд нийтлэгдэн гарч байв. Тус сэтгүүлийн анхны эрхлэгчээр Зөвлөлтийн нэрт улс төрийн эдийн засагч, академич Алексей Румянцев ажиллаж эхэлсэн байна. ЭТСА сэтгүүлийн Редакцид Зөвлөлд зөвлөлтийн нэрт эрдэмтэд академич Петр Н. Федосеев, академич Георгий Л.Смирнов, академич Георгий А.Арбатов, академич Иван Т.Фролов, элчин сайд Евгений А.Амбарцумов нар ЭТСА сэтгүүлд Хариуцлагатай нарын бичгийн дарга, Ерөнхий редакторын албыг хашиж байжээ. 1970-аад онд Редакцийн Зөвлөлд ЗХУКН, ЧКН, ГНСН, УАСН, ПАНН, РКН, ИКН, ФКН, АргКН, Их БритКН, ЭнэтКН, МАХН, ИракКН, АНУ-ын КН эдгээр 15 намын төлөөлөгчдөөс бүрдэж байжээ.

1960 оноос МАХН-ын ТХ-ны дэргэд ЭТСА сэтгүүлийн монгол Редакцийн газар ажиллаж эхэлсэн бөгөөд, 1970-аад онд тэнд Г.Аким, М.Дармааваанчиг, Ч.Лхагваа нарын зэрэг нэрт орчуулагч-утга зохиолын ажилтнууд идэвх

чармайлттай ажиллаж байжээ. Монгол Редакцийн газар ЭТСА сэтгүүлийн Прагад нийтлэгдсэн орос, англи эхийг Улаанбаатарт хүлээн авч монгол хэвлэлийг сард нь багтаан гаргаж, 1970-аад оны хоёрдугаар хагас гэхэд 5 мянган хувиар хэвлэгдэн гарч байжээ. МАХН-ын Төв Хороо ЭТСА сэтгүүлийн нийт зардлын 4.3 хувьтэй тэнцэх шимтгэлийг чехословакийн крон, ам. доллараар санхүүжүүлдэг байжээ.

Б.Лхамсүрэнг сэтгүүлд ажиллах хугацаанд НТХ-ны Бүгд хуралд дуудан ирүүлдэг байсан бөгөөд МАХН-ын XVII, XVIII Их хурлын тайлан илтгэлийн бэлтгэл, “Ази-Номхон далайн орнуудын хооронд харилцан үл довтлох, хүч үл хэрэглэх конвенц байгуулах” санаачилга, “МАХН-ын товч түүх”-ийн нэмж засварласан 3 дахь хэвлэлийн эхийг редакторлах ажилд оролцож байжээ.

ЗХУ-д өрнөсөн өөрчлөн байгуулалтын жилүүдэд ЭТСА сэтгүүл социализмыг боловсронгуй болгох арга зам, онолын асуудлууд, эдийн засгийн хөгжлийг хурдасгах, хөгжлийн социал-демократ загвар, улс төрийн шинэ сэтгэлгээ, ил тод байдал, олон улсын харилцаа, өнгөрсөн түүхийн бүрхэг асуудлуудыг жинтэй тусгаж байснаас гадна ХКН, СХН, ЮКН сэтгүүлийн үйл ажиллагаанд оролцож эхэлсэн явдал байв. Тухайлбал ХКН-ын ТХ-ны дэргэдэх Нийгмийн ухааны академийн эрдэмтэн судлаачид Дэн Сяопины онолыг тулгуур болгон БНХАУ дахь эдийн засгийн шинэчлэлийн үйл явцийн тухай бичиж эхэлжээ.

Дэлхий дахин, олон улсын коммунист болон ажилчны хөдөлгөөн, социалист системийн шинэ нөхцөлд ЭТСА сэтгүүлийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг шинэчлэх асуудлыг 1988 оны 4 дүгээр сард Прагад болсон ах намуудын зөвлөлгөөнөөр авч хэлэлцжээ. Зөвлөлгөөнд 84 намын төлөөлөгчид оролцож, дийлэнх нь сэтгүүлийг коммунист, ажилчны намуудын онол-мэдээллийн хамтын хэвлэл хэвээр байлгахын хамт үйл ажиллагааг нь шинэ сэтгэлгээний үзэл санаанд нийцүүлэн өөрчлөх, нийтлэлд намуудын бие даасан байдал, үзэл бодлын олон янз байдлыг хүндэтгэх, санал зөрөлдөөнтэй асуудлаар хэлэлцүүлэг явуулж, үнэнийг үл монополизлох, социал-демократ зэрэг өөр үзэл баримтлалтай намуудтай харилцан ярилцлага зохиох, сэтгүүлийн ажлын албыг интернационалчлах, ерөнхий редакторыг намуудаас ээлжлэн сонгодог болгох зэрэг ардчилсан саналуудыг дэмжсэн байна.

1986-1990 онд ЭТСА сэтгүүлийн эрхлэгчээр түүхийн ухааны доктор Александр М.Субботин томилогдон ажилласан бөгөөд урд нь тэрбээр Зөвлөлтийн Бүх Холбоотын Комсомолын байгууллагын нарийн бичгийн

дарга, «Труд» сонины Ерөнхий эрхлэгчээр ажиллаж байх үед тус сонин 10 сая хувиар хэвлэгдэн гарч байжээ. ЭТСА сэтгүүлийн сүүлчийн Ерөнхий эрхлэгчээр анх удаа ЗХУ-ын биш, Чехословакийн дипломатч Любомир Молнар томилогдож байв.

ЭТСА сэтгүүлд Зөвлөлтийн удирдагч М.Горбачевын хэвлэлийн төлөөлөгч дипломатч, Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Геннадий Герасимов, олон улсын асуудал хариуцсан туслах Анатолий Черняев, гол зөвлөхүүд болох ЗХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн, Зөвлөлтийн Улс төрийн шинжлэх ухааны нийгэмлэгийн тэргүүн Георгий Шахназаров, академич Георгий Арбатов, академич Иван Фролов, хэвлэлийн «Новости» агентлагийн захирал Егор Яковлев, ЗХУКН-ын ТХ-ны социалист орнуудын хэлтсийн зөвлөх, философийн ухааны доктор Александр Ципко, дипломатч, Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Евгений А.Амбарцумов, Нийгмийн ухааны академийн тэнхимийн эрхлэгч, профессор Эдвард А.Араб-Оглы нарын асуудал дэвшүүлсэн, шүүмжлэлт томоохон өгүүлүүд нийтлэгдэх болсон юм. Эдгээр эрдэмтдийн дийлэнх нь урд нь ЭТСА сэтгүүлийн газарт хариуцлагатай алба хашиж байжээ.

ЭТСА сэтгүүлийн сүүлийн дугааруудад АНУ-ын нэрт геополитикч З.Бжезинский, энхтайвны салбарын Нобелийн шагналт, цөмийн физикч, хүний эрхийн төлөө тууштай тэмцэгч Андрей Сахаров, Чехословакийн улс төрийн зүтгэлтэн Александр Дубчек, Югославын ардчилсан үзэлтэн Милован Дилас болон ХКН-ын ТХ-ны эрдэмтэн судлаачдын өгүүлүүд хэвлэгдэн гарч эхэлжээ.

Ийм чухал үеэд академич Б.Лхамсүрэн сэтгүүлийн зөвлөлд МАХН-ыг төлөөлөн идэвхтэй ажиллаж байсан юм. 1988 онд түүний халааг урд нь НТХ-ны үзэл суртлын хэлтсийн эрхлэгч, МҮЭ-ийн Төв Зөвлөлийн даргын алба хашиж байсан философийн ухааны дэд эрдэмтэн Г.Очирбат хүлээн авч Прагад томилогдон ажилласан байна. Г.Очирбат 1990 онд МАХН-ын ТХ-ны даргаар сонгогдсон юм.

ЭТСА сэтгүүлд монголын нэрт эрдэмтэд Байнгын төлөөлөгчөөр ажиллаж байсны дотор Ц.Дагвасүрэн,¹⁵ академич, Онц бөгөөд Бүрэн эрхт

¹⁵ Дагвасүрэн, Цэрэвийн 1923 онд Увс аймгийн Зүүнговь сумын “Баяннуур” хэмээх газар төржээ. 1933 оноос бага сургууль, 1942-1944 онд МАХН-ын Шинэ хүчний дээд сургууль, 1944-1946 онд Монголын Ардын Армид алба хаахдаа Цэргийн төв хэвлэл “Улаан Од” сонинд утга зохиолын ажилтан, 1946-1964 онд Намын төв хорооны зааварлагч, тасаг, сектор болон хэлтсийн эрхлэгч, 1950-1953 ЗХУКН-ын ТХ-ны дэргэдэх Намын дээд сургууль, 1957-1961 онд ЗХУКН-ын ТХ-ны дэргэдэх Нийгмийн ухааны академид суралцаж эдийн засгийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан. 1937 оноос Увс Зүүнговь суманд бичээч, сайн дурын бага сургуулийн багш, 1939 оноос тэнд МХЗЭ-ийн үүрийн нарийн бичгийн дарга, 1940 оноос аймгийн МХЗЭ-ийн хороонд бичээч, аж ахуйн эрхлэгч, сургууль пионерийн гүйцэтгэгч, 1944 оноос “Улаан од” сонинд утга зохиолын ажилтан, 1946 оноос МАХН-ын ТХ-нд зааварлагч, тасгийн эрхлэгч, 1953 оноос хэлтсийн эрхлэгч, 1961 оноос

элчин Б.Балдоо, философийн ухааны дэд эрдэмтэн Ц.Балхаажав, түүхийн ухааны дэд эрдэмтэн Цэндийн Намсрай, философийн ухааны дэд эрдэмтэн Цогтын Намсрай, эдийн засгийн шинжлэх ухааны доктор, профессор, сүүлд ЗХУ-д Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар ажилласан Ц.Гүрбадам нар томилогдон ажиллаж байв.

Социалист систем, олон улсын коммунист хөдөлгөөн өөрийн хүч боломжоо нэгэнт шавхаж дуусах нь тодорхой болсон үед 1990 оны 6 дугаар сард ЭТСА сэтгүүлийн газрыг татан буулгаж, барилга байшин нь хуучин эзэн Ромын католик сүмийнхээ мэдэлд шилжсэн ажээ.

Б.Лхамсүрэнгийн үйл ажиллагааных нь талаарх өөр нэг баримтыг энд дурдах ёстой. Тухайн үед МАХН-ын ТХ-ны аж үйлдвэрийн хэлтсийн эрхлэгчээр ажиллаж байсан доктор Ц.Гүрбадам 1994 хэвлүүлсэн “Ю.Цэдэнбал: бодрол” дурсамж зохиолдоо өгүүлэхдээ: 1981 оны «МАХН-ын XVIII их хурлын бэлтгэл ажил өрнөж байх үед манай нэг эрдэмтэн “Монгол Улс 15-20 жилийн дараа ХАА-аж үйлдвэрийн орноос аж үйлдвэр-ХАА-н орон болж хувирна гэж нөхөр Ю.Цэдэнбалын 1966 онд хийсэн дүгнэлт туйлын зөв, алсын хараатай байсан нь эдүгээ батлагдан хэрэгжлээ. Иймд намын Их хурлаас «БНМАУ-ыг аж үйлдвэр-ХАА-н орон боллоо хэмээн зарлах нь зүйтэй байна» гэсэн санал бичиж УТТ-ны гишүүдэд тараажээ. УТТ-ны зарим гишүүд тэрхүү саналыг дэмжиж байв. Миний хувьд дээрх саналын эсрэг байсан. Ийм эрс зөрүүтэй хоёр санал дүгнэлтийн талаар УТТ-ны гишүүд хэлэлцэж Б.Лхамсүрэн гуай бид хоёрын санал дүгнэлтийг сонсоод түүнийг Намын Их хурлын тайлан илтгэлд оруулахаар шийдсэн билээ» гэж бичсэн байдаг.

Б.Лхамсүрэн Прагаас дуудагдан ирж Намын XVIII Их хурлын бэлтгэл ажлын хүрээнд НТХ-ны УТТ-ны хуралд оролцжээ. Энэ тухай тэрбээр өөрийн дурсамждаа: Намын XVIII Их хурлын өмнө тус хуралд тавих НТХ-ны тайлан илтгэлийн төслийг УТТ-гоор хэлэлцэхэд намайг байлцуулсан юм. Монгол Улс гурван 5 жилийн дараа аж үйлдвэр-ХАА-н орон болно гэж Ю.Цэдэнбалын хэлсэн үг биелэгдлээ хэмээн зарим эдийн засагчдын үзсэн саналыг тайлан илтгэлд тусгах эсэх тухай хэлэлцэхэд ийм санал

МАХН-ын ТХ-ны дэргэдэх Намын түүхийн институтийн орчуулагчийн секторын эрхлэгч, 1963 оноос МАХН-ын ТХ-нд Соёлын хэлтсийн эрхлэгч, 1964-1971 онд “Энхтайван социализмын асуудал” сэтгүүлийн газарт суугаа МАХН-ын төлөөлөгч, 1971-1977 онд МАХН-ын ТХ-ны хэлтсийн эрхлэгч, 1978-1981 онд БНМАУ-аас БНАГУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар ажиллаж байв. 1981-1984 онд ЗХУ-ын Москва хотод Удирдлагын асуудлыг судлах олон улсын эрдэм шинжилгээний хүрээлэнд эрдэм шинжилгээний ахлах ажилтнаар тус тус ажиллаж байгаад өндөр настны тэтгэвэрт гарчээ. Аугаа эх орны дайны ахмад дайчин, ахмад дипломатч, өдгөө ОХУ-ын Москва хотын Ясенево дүүрэг дэх эх орны дайны ахмад дайчдын хотхонд амьдарч байна. “Хөдөлмөрийн гавьяаны улаан туг”-ийн одон, “Алтан гадас” одон, “Хөдөлмөрийн хүндэт медаль”, улс хувьсгалын болон салбарын ойн медалиудаар шагнагдаж байжээ.

гаргасан хүмүүс үндэсний орлогод аж үйлдвэр, ХАА-н бүтээгдэхүүний хувийн жингээр шалгуур хийж бусад олон зүйлийг харгалзаж үзээгүй байна. Хувийн дүгнэлтээ намын баримт бичигт оруулах гэж хөөцөлдөөд байх нь зарчмын хувьд буруу гэж бодож байгаагаа шууд хэлж, энэ талаар хэт яарсан дүгнэлт хийхгүй байх саналаа хэлсэн юм. Нөхөр Ю.Цэдэнбал XVIII Их хуралд тавьсан тайлан илтгэлд 15 жилийн өмнө өөрийн хийсэн таамаглалаас татгалзан харин социалист аж үйлдвэржүүлэлтийн явцыг гүнзгийрүүлэх зорилтыг тавьсан нь зүйтэй болсон билээ гэсэн байдаг. Энэ нь Б.Лхамсүрэнгийн асуудалд туйлын бодитой, шинжлэх ухааны үндэстэй хандаж байсны тодорхой баримт мөн.

МАХН-ын ТХ-ны Гадаад харилцааны хэлтсээс Б.Лхамсүрэнг Прагаас төвд дуудсан тул 1981 оны 4 дүгээр сард Улаанбаатар хотноо ирж, МАХН-ын ТХ-ны УТТ-ны шийдвэрээр НТХ-ны дэргэдэх Намын түүхийн институтийн захирлаар томилогджээ. Намын гадаад, дотоод бодлогыг боловсруулах, онолын сэтгэлээг хөгжүүлэхийг нөхөр Ю.Цэдэнбал чухалчлан үзэж, тус байгууллагад ажиллуулах болсныг тэрбээр өөрт нь үзүүлсэн өндөр итгэл гэж үзсэн юм.

1975 оны 5 дугаар сард МАХН-ын УТТ-ноос НТХ-ны тогтоол шийдвэрийг Намын түүхийн институт хангалтгүй биелүүлж байгаа тухай тогтоол гарч мөн институтийн захирал байсан Б.Балдоо¹⁶ 1976 онд дипломат албанд шилжсэнээс хойш 5 жилийн турш институт хэрэг дээрээ захиралгүй явж ирснээс гадна институтийн орлогч захирал түүхийн шинжлэх ухааны доктор А.Минисийг шүүмжилсэн ил захидал нийтлэгдэж шуугиан дуулиан болсон нөхцөлд тус институтийн захирлын тушаалыг хүлээн авч, НТХ-ны онол-эрдэм шинжилгээний чухал төвийн нэр хүнд, үйл ажиллагааг шаардлагын түвшинд хүртэл дээшлүүлэхийг өөрийн гол үүрэг гэж үзжээ.

Үүний тулд юуны өмнө Намын түүхийн институтийг намын түүхээ гүнзгийрүүлж судлахын зэрэгцээ намын онолын сэтгэлгээг хөгжүүлж шинэ шатанд гаргах, социалист байгуулалтын онолын асуудлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, намын гадаад, дотоод бодлогыг

¹⁶ **Б.Балдоо** нь ШУА-ийн жинхэнэ гишүүн, философийн ухааны дэд эрдэмтэн Б.Лхамсүрэнтэй хамт 1947 онд МУИС-ийн математик-физикийн ангийг төгссөн, 1947-1955 онд МАХН-ын ТХ-нд лектор, референт, тасгийн эрхлэгч, 1955-1958 онд ЗХУКН-ын ТХ-ны дэргэдэх НУА-ийн аспирантур, 1959-1960 онд Прагад ЭТСА сэтгүүлийн Редакцийн Зөвлөлд суугаа МАХН-ын Төлөөлөгч, 1960-1961 онд НТХ-ны дэргэдэх Намын түүхийн институтийн орлогч захирал, 1961-1962 онд МУИС-ийн философийн тэнхимийн эрхлэгч, 1962-1963 онд “Үнэн” сонинь Суртлын хэлсийн эрхлэгч, 1963-1976 онд Намын түүхийн институтийн орлогч эрхлэгч, 1976-1978 онд БНАСАУ, 1978-1980 онд БНЭУ-д, 1980-1983 онд БНУАУ-д элчин сайдаар, 1984-1990 онд НТХ-ны дэргэдэх Нийгмийн ухааны институтийн захирал, 1990-1999 онд ШУА-ийн Зүүн Ази судлалын төвд зөвлөх, 2000-2003 онд ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнд зөвлөхөөр ажиллаж байв. “Онц бөгөөд Бүрэн эрхт элчин” дипломат цол хүртсэн.

боловсруулах чиглэлээр ажилладаг болгон үүргийг нь өргөтгөн өөрчлөн зохион байгуулах, боловсон хүчнээр бэхжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр өгөөжийг дээшлүүлэх тухай саналаа Ю.Цэдэнбал даргад илтгэхэд тэрбээр дуртай хүлээн авчээ.

Чингээд МАХН-ын XVIII Их хурлын тайлан илтгэлд Намын түүхийн институтийг өөрчлөн байгуулж, намын түүхийн судалгааг цаашид гүнзгийрүүлэх, социалист байгуулалтын онолын асуудал, олон улсын коммунист хөдөлгөөн, БНМАУ-ын капиталист бус хөгжлийн туршлага, социалист чиг баримтлал, хөрөнгөтний болон маоист үзэл сурталд няцаалт өгөх зэрэг зангилаа асуудлуудыг боловсруулах явдлыг тус институтийн үйл ажиллагааны үндсэн чиглэл болговол зохино гэж заажээ.

Тийнхүү МАХН-ын их хурлын дараахан УТТ-ны 307-р тогтоолоор Намын түүхийн институтийг НТХ-ны дэргэдэх Нийгмийн ухааны институт¹⁷ болгон өөрчлөн байгуулах, зорилт, үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлж, эрдэм шинжилгээ эрхэлсэн орлогчоор А.Минис, Лениний музей, санхүү эрхэлсэн орлогчоор Ж.Роозон, эрдэмтэн нарийн бичгийн даргаар Б.Сумьяа нар ажиллаж, түүхч эрдэмтэн С.Дамдинсүрэн, Лха.Бат-Очир, Б.Лигдэн, Д.Даш, Д.Цэрэндорж, К.Зардыхан, О.Пүрэв, З.Лонжид, Б.Монц, эдийн засагч эрдэмтэн Ш.Жумдаан, Х.Хусаин, Я.Цэгмид, дээд сургууль төгсч ирсэн Ө.Энхтүвшин, Г.Чулуунбаатар, Х.Маам, Л.Оюунгэрэл, Д.Ганхуяг, Т.Лхагваа, Ч.Эрдэнэчимэг зэрэг ахмад болон залуу боловсон хүчнийг хослуулан ажиллуулж эхэлжээ.

Энэ үед МУИС-ын МАХН-ын түүхийн тэнхим МАХН-ын ТХ-ны дэргэдэх Д.Сүхбаатарын нэрэмжит НДС, УБДС-ийн МАХН-ын түүхийн профессор багш нар МАХН-ын түүхийн цуврал лекцийг хэвлэн гаргахаар бэлтгэж байжээ. 1980 онд цувралын “МАХН-ын түүхийн лекц” (1921-1940) гэсэн нэгдүгээр дэвтэрийг МУИС-ийн МАХН-ын түүхийн тэнхимийн эрхлэгч, түүхийн ухааны дэд эрдэмтэн, доцент Лу. Бат-Очирын удирдлага дор эрхлэн хэвлэн гаргажээ. Энэхүү нэгдүгээр дэвтэрт Монгол оронд ард ангийн хувьсгалт нам байгуулагдсан асуудал тодорхой хөндөгдөж, МАХН-ыг үүсгэн байгуулахад зөвхөн малчин ард анги төдийгүй нийгмийн янз бүрийн бүлэг, давхарга тухайлбал жижиг түшмэд, зарим эх оронч үндэсний үзэлт ноёд, лам нар, худалдаачид чухал үүрэг гүйцэтгэсэн тухай хийсэн дүгнэлтийг Нийгмийн ухааны институтийн зарим судлаачид эрс буруутган

¹⁷ Нийгмийн ухааны институт 1990 оноос НТХ-ны дэргэдэх Эрдэм шинжилгээний төв, 1994 оноос Сургалт-судалгааны Прогноз төв, 1996 оноос Нийгэм-улс төрийн судалгааны Прогноз хүрээлэн, 2005 оноос Сургалт, судалгааны Прогноз Академи, 2012 оноос Нийгмийн Ардчиллын Хүрээлэн, 2013 оны 10-р сард хуралдсан МАН-ын XXVII Их хурлаас батласан Намын үндсэн Дүрэмд зааснаар Стратеги Академийг 2014 онд шинэчлэн зохион байгуулж, эрдэм шинжилгээний бие даасан хараат бус статустай болсон байна.

МАХН-ын түүхийг мушгин гуйвуулсан хэмээн зохиогчдыг шалгах комисс байгуулах хүртэл үйл явдал болж өрнөжээ. Үүнийг институтийн шинэ захирал доктор Б.Лхамсүрэн хүрээлэнгийн удирдлагын түвшинд авч хэлэлцээд институтийн судлаачдын санал шүүмжлэлийг таслан зогсоож, түүхийн шинжлэх ухааны судалгаанд олон ургальч үзэл нэн чухал болохыг онцлон тэмдэглэж байжээ. Хэрэв дээрх судлаачдын саналыг үндэслэн НТХ тогтоол гаргасан бол томоохон хэлмэгдүүлэлт болж өнгөрөх байсан нь тодорхой байсан юм. Энэ үйл явдлын тухай профессор Лу.Бат-Очир багш хожим надад ярьж байсныг энд зориуд тэмдэглэе. Манай оронд өөрчлөн байгуулалт, ил тод байдал, улс төрийн шинэ сэтгэлгээ өрнөж байсан 1980-аад оны сүүлчээр тухайн үед захирал Б.Лхамсүрэнгийн баримталж байсан байр суурь үнэн зөв болох нь дахин нотологдсон билээ.

Академич Б.Лхамсүрэн Нийгмийн ухааны институтийн захирлаар ажиллаж байх дор “МАХН-ын товч түүх” бүтээлийн 3 дахь удаагийн хэвлэлийн редакцийн комиссын даргаар ажиллаж 1985 онд тус бүтээлийг эрхлэн хэвлүүлэн гаргажээ. Түүнд 1930-аад оны сүүлээр Монголд Х.Чойбалсанг тахин шүтэх үзэл буй болж, улс төрийн талаар олноор хэлмэгдүүлэх үйл явц эхэлсэн талаарх асуудлыг анх удаа тусгасан байна. 1985 онд хэвлэгдсэн «МАХН-ын товч түүх»-ийн нэмж засварласан 3 дахь удаагийн хэвлэлийг Б.Лхамсүрэн ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэнгийн нэрт эрдэмтэн, миний «БНМАУ-ын дипломат албаны үндэс суурь тавигдсан нь» сэдэвт МУИС-ийн төгсөлтийн дипломын ажлын удирдагч доктор Ш.Сандагт тусгайлан даалгаж, тэрбээр 1 сарын хугацаанд оросоор маш сайн орчуулж, 1986 онд «Краткая история МНРП» нэртэй хэвлэгдэн гарч байсан юм.

1981 оны 12 дугаар сард МАХН-ын ТХ-ны НХШХ-ноос ШУА-ийн Ерөнхийлөгч “Нөхөр Б.Ширэндэвийн зарчимгүй, хариуцлагагүй, нэр алдар хөөцөлддөг зан байдал, үйл ажиллагааны тухай” элдэв зүйлийг хамж шимсэн тогтоолыг нийтэлж, 1983 сүүлчээр НТХ-ны УТТ-ны гишүүн, Нарийн бичгийн дарга байсан С.Жалан-Аажавыг “матсан дуулиант хэрэг”, 1984 оны эхээр Д.Майдар, А.И.Филатова нараас Эрдэнэт үйлдвэрийн үр ашгийн асуудлыг нааштай шийдээд байсан үед түүнийг улс төржүүлэн НХТ-ны УТТ-ны гишүүн Д.Моломжамц, СнЗ-ийн орлогч дарга бөгөөд Улсын төлөвлөгөөний комиссын дарга Д.Содном, Улсын төлөвлөгөөний комиссын Нэгдүгээр орлогч дарга, Монгол Улсын сайд П.Жасрай, НТХ-ны аж үйлдвэрийн хэлтсийн эрхлэгч Н.Мишигдорж, Сангийн яамны 1 дүгээр орлогч сайд доктор Б.Долгормаа нарыг Монгол-Зөвлөлтийн харилцааны үр ашгийг үгүйсгэгчид хэмээн албан тушаалаас нь зайлуулах саналыг

Ю.Цэдэнбалд тавьж, хэрэгжүүлэхээр бэлтгэж байсан нарийн ээдрээтэй гэмээр цаг үед Б.Лхамсүрэн бээр НТХ-нд ажиллаж байв.

Тиймээс ч 1984 оны эхээр ЭТСА сэтгүүлийн газар суугаа МАХН-ын Төлөөлөгч Ц.Гүрбадам Москвад элчин сайдаар томилогдсон тул тус сэтгүүлд намын төлөөлөгчөөр дахин очиж ажиллахыг нөхөр Ю.Цэдэнбал санал болгоход тэрбээр татгалзаагүй юм. Чингэж 1984 оны 6 дугаар сараас ЭТСА сэтгүүлийн Зөвлөлд суух МАХН-ын Төлөөлөгчөөр хоёр дахь удаагаа 4 жил ажиллажээ. Дурдсан хугацаанд 1986 оны 6 дугаар сард хуралдсан МАХН-ын XIX хурлын тайлангийн бэлтгэл, тус их хурлаас дэвшүүлсэн Цөмийн дайны аюулыг сэрэмжлэн зайлуулахад Азийн орнуудын улс төрийн нам, парламент, ҮЭ, залуучууд, эмэгтэйчүүд зэрэг олон нийтийн янз бүрийн байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэж байгааг харгалзан Азийн орнуудын өргөн нийтийн төлөөлөгчид оролцсон энхтайван, хамтын ажиллагааны төлөө “нийт Азийн чуулга” уулзалт хийх санаачилга, 1987 оны 7 дугаар сард Улаанбаатар хотноо зохиогдсон Ази-Номхон далайн орнуудын коммунист, ажилчны намуудын зөвлөлдөх уулзалтын бэлтгэл ажилд оролцож байв.

Тэрбээр 1988 оны 6 дугаар сард Прага дахь ЭТСА сэтгүүлийн газар дахь төлөөлөгчийн ажлаасаа чөлөөлөгдөн шинэчлэл, өөрчлөлтийн эхний жилүүдэд МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Батмөнхийн зөвлөхөөр томилогдон ажиллаж, Монгол дахь өөрчлөн байгуулалтын онолын баримтлалыг боловсруулах, Намын зохион байгуулалт, үзэл суртлын ажлыг сайжруулах, МАХН-ын Программыг шинэчлэх, Намын эдийн засаг, нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх шинэ, тэр хэмжээгээр амаргүй ажилд мэдлэг, авьяас билгээ зориулсан юм.

Б.Лхамсүрэн МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргын зөвлөхийн хувьд өөрчлөн байгуулалтын эхлэлийг тавьсан НТХ-ны V Бүгд хурлын үндсэн илтгэлийг бэлтгэлцсэн голлох эрдэмтдийн нэг байсан бөгөөд тэрхүү илтгэлд Монгол Улсад гадаад харилцааны салбарт багагүй дутагдал оршиж байгааг анх удаа хурц шүүмжилсэн юм. Үүнд: *нэгд*, Улс орны дотоод амьдралын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гадаад харилцааны өргөн боломжийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгаа, *хоёрт*, гадаад улс төр, гадаад эдийн засгийн бодлогын харилцан шүтэлцээ, цогц байдлыг зөв хослуулах, *гуравт*, олон улсын байдал болон гадаад харилцааны асуудалд олон түмний санаа бодлыг судалж сонсох, нарийн судалгаа, дүн шинжилгээтэй хандах явдал дутагдалтай, *дөрөвт*, ил тод байдал хязгаарлагдмал, голдуу тунхаглах, лоозонгнох шинжтэй байгааг шүүмжлээд үзэл суртал, бусад ялгааг шалтаг болохгүйгээр энхтайвнаар зэрэгцэн орших, итгэлцэх, сайн хөрш байх үндсэн дээр өндөр хөгжилтэй

Өрнөдийн орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг тогтоон хөгжүүлэх нь цаг үеийн бодит байдалд нийцсэн олон улсын харилцааны ирээдүйтэй хандлага болсныг анх удаа онцлон тэмдэглэсэн юм.¹⁸

Б.Лхамсүрэн МАХН-ын ТХ-ны V Бүгд хурлын гадаад бодлоготой холбоотой шийдвэрийг үндэслэн 1989 оны 4 дүгээр сард БНМАУ-ын Засгийн газраас дэвшүүлсэн “Ази-Номхон далайн бүсийн хойд хэсгийн орнуудын хооронд байнга үйлчлэх яриа хэлэлцээний механизм” бий болгох санаачилгыг боловсруулахад оролцсон бөгөөд тэрхүү механизмд анх удаа БНСУ-ыг татан оролцуулах саналыг оруулсан байв.

Б.Лхамсүрэн Монголын ШУА-иас эрхлэн 1990 онд Их Британид англи хэлээр хэвлэгдэн гарсан “*Information Mongolia*”. Oxford Pergamon Press. 1990, 550 pp.” томоохон бүтээлийн зохиогч, Ерөнхий редактораар ажилласан юм.

Тэрбээр 1990 оны 12 дугаар сараас 2003 он хүртэл ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнд зөвлөхөөр ажиллаж эрдмийн зохиол бүтээлээ туурвиж, монголын нэр хүндтэй эрдэмтдийн эрдэм судлалын ажилд өөрийн хувь нэмрийг оруулжээ. Түүний 1995 онд хэвлүүлсэн “Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол” бүтээлийг нь ОХУ-ын ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэнгийн монголч эрдэмтэд өндрөөр үнэлсэн юм.

Тэрбээр 1996 онд нэрт түүхч Л.Жамсрангийн “Монголын тусгаар тогтнолын сэргэлт ба Монгол, Хятадын харилцаа 1911-1949 он” сэдэвт, 1998 онд Ц.Батбаярын “Монгол, Японы харилцаа: XX зууны тэргүүн хагаст” сэдэвт түүхийн шинжлэх ухааны докторын ажлын эрдэм шинжилгээний удирдагчаар, 1995 онд О.Батсайханы “Монгол Улсыг хөгжүүлэх үндэсний ардчилсан чиг баримтлал (1921-1932)” сэдэвт дэд докторын ажлын эрдэм шинжилгээний удирдагчаар, 2002 онд “Монголын тусгаар тогтнол ба Орос, Монгол, Хятадын гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ” сэдэвт түүхийн шинжлэх ухааны докторын ажлын эрдэм шинжилгээний зөвлөхөөр тус тус, Д.Шүрхүүгийн “Монгол, Тувагийн харилцаа: XX зууны тэргүүн хагаст” сэдэвт түүхийн шинжлэх ухааны дэд докторын ажлын удирдагчаар 2001 онд ажилласан юм.

Б.Лхамсүрэн гуайн халамжит хань Л.Тоодой эгчийн тухайд өгүүлэхэд тэрбээр Монголын хамгийн оюунлаг, эрдэмтэн сэхээтэн цөөхөн эмэгтэйчүүдийн нэг, сайн ээж, сайхан хань, гол өмөг түшиг нь байсан билээ. Л.Тоодой эгч бол миний аавын төрсөн дүү бөгөөд 1928 онд Хөвсгөл аймагт

¹⁸ Ж.Батмөнх. «Намын зохион байгуулалт, үзэл суртлын ажлыг сайжруулах шинэ зорилтын тухай» илтгэл. МАХН-ын Төв Хорооны V Бүгд хурал. УБ., 1988, 108-109 дэх тал

төрж, 1953 онд Эрхүү хотын Санхүү, эдийн засгийн дээд сургуулийг гадаад худалдааны эдийн засагч мэргэжлээр төгсч, дараа нь Санхүү, эдийн засгийн техникумд багш, Гадаад худалдааны яаманд мэргэжилтэн, хэлтсийн дарга, экспорт-импортын газрын дарга зэрэг хариуцлагатай алба хашиж байсан юм. 1979 онд тэрбээр ЗХУ-ын ШУА-ийн өндөр нэр хүндтэй Дэлхийн эдийн засаг, олон улсын харилцааны хүрээлэнд «Внешнеэкономическое сотрудничество и его роль в развитии народного хозяйства МНР» сэдвээр эдийн засгийн шинжлэх ухааны дэд эрдэмтний зэргийг ЗХУ-ын ШУА-ийн Дэлхийн социалист системийн эдийн засгийн хүрээлэнгийн захирал академич О.Т.Богомоловын удирдлага дор амжилттай хамгаалж, Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцааны сэдвээр эрдмийн зэрэг хамгаалсан анхны эмэгтэй болсон юм.

Б.Лхамсүрэнгийн ухамсарт амьдрал, үйл ажиллагаа чухамхүү XVI жарантай үндсэндээ тохиосон бөгөөд өөрийн үеийнхний нэгэн адил энэ жарны үйл явдлын гэрч төдийгүй, тэрхүү түүхийг бүтээгчдийн нэг болсон юм. Тэрбээр төр нийгмийн нэрт зүтгэлтэн, дипломатын Онц бөгөөд Бүрэн эрхт элчин цолтой, ШУА-ийн жинхэнэ гишүүн, академич нэр хүндтэй томоохон эрдэмтэн мөн билээ. Аливаа хүмүүний хийж бүтээсэн гавьяа зүтгэлийг амьд ахуй үед нь алдаршуулах нь юутай ч үл зүйрлэх чухал нь билээ. Энэ нь хэн бүхэнд асар их эрч хүч, урам зориг өөрийн эрхгүй түрүүлдэг жамтай ажгуу.

НОМЗҮЙ

1. Лхамсүрэн Б. «Внешняя политика МНР и развитие её международных связей после второй мировой войны (1921-1957 гг.)» Автореф. канд. дисс., М., 1958
2. Лхамсүрэн Б. «Воплощение в деятельности МНРП принципов интернационализма». Автореф. докт. дисс., М., 1975
3. Лхамсүрэн Б. «Из истории внешних сношении Монгольской Народной Республики (1921-1945 гг.)». Двухмесячный жур: *“Современная Монголия”*. Май-Июнь 1957 год, стр. 22-32
4. Лхамсүрэн Б. «Из истории внешних сношении Монгольской Народной Республики (1945-1957 гг.)». Двухмесячный жур: *“Современная Монголия”*. Январь-Февраль 1958 год, стр. 21-33
5. Лхамсүрэн Б. «МНР в борьбе за мирное сосуществование» Двухмесячный жур: *“Современная Монголия”*. Май-Июнь 1958 год, стр. 3-11
6. Лхамсүрэн Б. МАХН-ын үйл ажиллагаанд интернационализмын зарчим хэрэгжсэн нь. УБ., 1976
7. Лхамсүрэн Б. Монгол, Хятадын харилцааны талаархи МАХН-ын интернационалч байр суурь. УБ., 1984
8. МАХН-ын товч түүх. Нэмж засварласан гуравдахь хэвлэл (Редакцийн комиссын дарга ШУА-ийн сурвалжлагч гишүүн Б.Лхамсүрэн). УБ., 1985
9. Лхамсүрэн Б. Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол. УБ., 1995
10. Лхамсүрэн Б. Арван зургадугаар жаран мину (Дурсамж). УБ., 2003
11. Академич Бадамын Лхамсүрэн: Эрдмийн бүтээл I. (Эрхэлсэн О.Батсайхан) УБ., 2013
12. Академич Бадамын Лхамсүрэн: Эрдмийн бүтээл II. (Эрхэлсэн О.Батсайхан) УБ., 2013